

Австралид хосын болон гэр бүлийн хүчирхийллийг огтхон ч хүлээн зөвшөөрдөггүй

Таны гэр бүлийн гишүүд юм уу эсвэл таны хамтран амьдрагч:

Танд эсвэл таны хүүхдүүдэд айдас төрүүлж байна уу?

Таныг эсвэл таны хүүхдүүдийг цохих юм уу гэмтээдэг үү?

Таныг хүсээгүй байхад ч бэлгийн харьцаанд орохыг танаас шаарддаг уу?

Орилж хашгиран, юм шидэх эсвэл эд зүйлсийг эвддэг үү?

Таныг доромжлох, эсвэл өөрийг тань хэн ч биш гэж мэдрүүлдэг үү?

Таныг өөрийн гэсэн мөнгөтэй байхыг хорьдог уу?

Таныг гадагш гарах, бусадтай уулзахыг хорьдог уу?



Хэрэв та эдгээр асуултын аль нэгэнд нь “тийм” гэж хариулсан бол та хосын болон гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байж болзошгүй юм.

Танд хамгаалуулах эрх бий. Хосын болон гэр бүлийн хүчирхийлэл нь хууль бус юм. Шинээр ирж суурьшигчид, түр визтэй хүмүүс зэрэг хүн бүр хуулиар хамгаалагдсан байдаг.

Та дэмжлэг туслалцаа авах боломжтой. Өөрийн эмч эсвэл эрүүл мэндийн ажилтантайгаа ярилцаарай. Та уг гэр бүлийн харилцаагаа хэвээр үлдээх эсвэл харилцаагаа таслах эсэхээс үл хамааран бид таньд дэмжлэг туслалцаа үзүүлэх болно.

Мэргэжлийн орчуулагчийн үйлчилгээг өөрийн хэл дээр, үнэ төлбөргүй авахыг хүсч байвал биднээс асуугаарай.

Орон нутагт холбогдох (Local contact):

Байгууллага/Үйлчилгээний

нэр: (Service):

Утас (Phone):

Өөр бусад дэмжих үйлчилгээ үзүүлдэг 24 цагийн тусламжийн шугамууд байдаг. Үүнд:

1800RESPECT

1800 737 732

NSW Domestic Violence Helpline (Шинэ Өмнөд Уэльс мужын

Гэр бүлийн хүчирхийллийн тусламжийн шугам)

1800 65 64 63

Lifeline Australia (Лайфлайн Австралиа)

13 11 14

Өөрийн хэлээр тусламж авахыг хүсвэл Орчуулгын Алба (TIS) -ны 131 450 дугаарт залгаж, холбогдохыг хүсч буй байгууллагынхаа нэрийг хэлээрэй.

Онц яаралтай эсвэл амь насанд аюултай нөхцөл үүсвэл 000 дугаарт залгана уу.